



ДАСАН ЗОХИЦОХ ИНТЕГРАЦИЛАЛЫН ДАМЖАА

Чех Улсад тавтай морилно уу



2021.01.01-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН ГУРАВДАГЧ ОРНЫ ЗОРИЛТОТ БҮЛГИЙНХЭНД ШИ-
НЭЭР НЭМЭГДЭЖ БАЙГАА ҮҮРЭГ: ДАСАН ЗОХИЦОХ, ИНТЕГРАЦИЛАЛЫН ДАМЖАА

Дасан зохицох, интеграцчилалын дамжаанд сууснаар та хамгийн богино хугацаанд чех орны талаар анхан шатны ойлголттой болохоос гадна эдлэх эрх үүрэгтэйгээ танилцах боломжтой.

ДАМЖААНД ХЭН ХАМРАГДАХ ҮҮРЭГТЭЙ ВЭ?

2021.01.01-ний өдрөөс хойш Чех Улсад удаан хугацааны оршин суух зөвшөөрөл авсан, эсвэл байнга оршин суух зөвшөөрөл олгох нөхцөл болзлоос чөлөөлөх заалтын дагуу байнга оршин суух зөвшөөрөл авсан зорилтот бүлгийн гадаадын иргэд энэхүү дасан зохицох, интеграцчилалын дамжаанд хамрагдах үүрэг хүлээж байна. Тус улсын **Дотоод хэргийн яамны цахим хуудаснаас** уг дамжаанд суух үүрэг хүлээж байгаа гадаадын иргэдийн дэлгэрэнгүй жагсаалт, хуульд заасны дагуу уг үүргээс чөлөөлөгдсөн зорилтот бүлгийнхэнд зориулсан мэдээллийг үзнэ үү:




ДАМЖААГ ЯМАР ХУГАЦААНД ДҮҮРГЭХ ВЭ?

Дасан зохицох, интеграцчилалын дамжаанд хамрагдах үүрэг хүлээж байгаа гадаадын иргэдийн оршин суух зөвшөөрөл хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн нэг жилийн дотор уг дамжааг дүүргэх бөгөөд хугацааг нь гуравдагч орны иргэд биеийн давцахгүй өгөгдөл бүхий цахим үнэмлэхээ (ePKP гэж товчилно) авсан өдрөөс эхэлж тоолно.

ДАМЖААНД ХААНА БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

Зөвхөн **FRS портал** сайтаар орж дамжаанд бүртгүүлж, төлбөрөө төлнө: www.frs.gov.cz



ДАМЖАА ХААНА БОЛДОГ ВЭ?

Гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих төвийн байранд зохион байгуулж байгаа (олон нийтэд зориулсан дамжаа), эсвэл хуулийн этгээдээс (жишээ нь: танай ажил олгогчоос) интеграцчилалын төвтэй хамтран зохион байгуулж байгаа дамжаанд (хаалттай дамжаа) сууна. Чех Улсын хэмжээнд 18 интеграцчилалын төв үйл ажиллагаа явуулж байна. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг QR кодоор нэвтрэн орох эсвэл цахим хуудаснаас үзнэ үү: www.integracnicentra.cz



ДАМЖАА ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:

4 цаг

ДАМЖАА ЯМАР ҮНЭТЭЙ ВЭ?

Олон нийтэд зориулсан дамжаа 1500 чех крон.

ДАМЖАА ЯМАР ХЭЛЭЭР ХИЧЭЭЛЛЭДЭГ ВЭ?

Дамжааг чех хэлээр явуулж, англи, орос, украин, испани, франц, серб, монгол, араб, вьетнам гэсэн 9 хэл рүү хэлмэрчилдэг.

Дасан зохицох, интеграцчилалын дамжааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг www.vitejtevcr.cz цахим хуудаснаас үзнэ үү.



АНХААР!!!

Зөвхөн www.integracnicentra.cz цахим хуудсанд цэс үүсгэдсэн гадаадын иргэдийн интеграцчилалыг дэмжих аль нэг төвөөс зохион байгуулж байгаа албан ёсны дамжааг дүүргэсэн тохиолдолд үүргээ биелүүлсэнд тооцно.

Зөвхөн дээр дурдсан холбоосоор орж мэдээлэл авч, дамжаанд бүртгүүлэхийг анхаарна уу.



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY

